



СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 11. 22 № А-11/4418  
танай -ны № -т

Тендер шалгаруулалтын баримт  
бичигт өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ЭЗХЯ/20240103158 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгатай холбогдуулан дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

- ТШЗ 26.1. “Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр. Цаг 10 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр. Цаг 10 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.2. “Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр. Цаг 10 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр. Цаг 10 цаг 10 минут” гэж тус тус өөрчлөв.

Дээрх төсөл, арга хэмжээний захиалагч Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хургуулэв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.12-т заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

Хавсралт: 3. хуудастай.

ДАРГА

Ц.БАТЗУЛ

9020020105 СБТ-е 11261 6529909

132401011324



МОНГОЛ УЛСЫН  
АЖ УЙЛДВЭР,  
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 35 06,  
Цахим шуудан: info@mimr.gov.mn,  
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2024.11.15 № 03 | 1053  
танай 2024.11.12 -ны № А.1 | 4300т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА  
Ц.БАТЗУЛ ТАНАА

Танай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны  
өдрийн А-1/4300 дугаар албан бичгээр ирүүлсэн  
хүсэлтийн дагуу “Газрын тосны бүтээгдэхүүний  
улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг  
төсөв” төсөл, арга хэмжээний ажлын даалгавартай  
холбоотой тодруулгыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИИГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР



1508 11 0540

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН НӨӨЦИЙН АГУУЛАХЫН ЖИШИГ  
НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАРТАЙ  
ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА МЭДЭЭЛЭЛ**

**1. Ажлын даалгаврын 11.5 дахь заалтын технологийн даалгавар хэсэг:**

Өнөөдрийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2021 онд 1.8 сая тонн, 2022 онд 1.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж байсан бол 2023 онд импортын хэмжээ 2.4 сая тонн болж өмнөх оноос даруй 21 хувиар өссөн байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж тусгасан.

Манай улсын түлш, шатахууны хэрэглээг сүүлийн 3 жилээр төрлөөр авч үзвэл:

№	Төрөл	2022 он	2023 он	2024.11 сар
1	Аи-92 автобензин	626,345	686,296	717,744
2	Аи-95 автобензин	22,118	20,671	15,665
3	Аи-98 автобензин	586	422	
4	Дизель түлш	987,873	1,341,693	1,401,051
5	ТС-1 агаарын хөлгийн түлш	38,492	61,719	67,834
6	Бусад	234,062	304,420	208,987
Нийт		1,909,476	2,415,221	2,411,281

Иймд дараах байдлаар урьдчилан төлөвлөх шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улсын шатахууны импорт, хэрэглээний хэтийн төлөв болон импортолж буй боомтууд, төмөр зам, авто тээврийн сүлжээ, тээврийн нөхцөл боломж, хэрэглээг бүс тус бүрээр тооцож, агуулахын оновчтой байрлалыг тодорхойлсон эдийн засгийн тооцоо судалгаа хийх;
- Дээрх эдийн засгийн тооцоог үндэслэн агуулахын оновчтой багтаамж, байршлыг тодорхойлох;
- Тодорхойлсон байршил, багтаамж дээр тулгуурлан агуулахын төрөл тус бүрээр савны too хэмжээ, багтаамжийг уялдуулан тодорхойлох;
- Агуулах бүрд жижиглэн худалдаа хийх боломжтой ШТС төлөвлөх;
- Агуулахын багтаамж хүчин чадалтай уялдуулан газрын тосны бүтээгдэхүүнийг вагон цистернээс буулгах, ачих стакадыг төлөвлөх;
- Мөн 3-6 сарын улсын нөөцийн түлш, шатахуун хадгалахад шаардлагатай хөрөнгө оруулалтын эдийн засгийн тооцоо, бүтээгдэхүүний үнэ, агуулахын байршлын оновчлол, ашиглалтын үеийн зардал, хүн хүчний тооцоог тус тус тодорхой тусгах.

2. Ажлын даалгаврын 5,6,7,8,9,10 дугаар заалт:
  - Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв боловсруулах ажилд тухайн агуулахын байршилаас хамаарсан инженер, хайгуулын судалгаа, цахилгаан хангамж, төмөр замын зураг төсөл, төсвийг “Үндсэн зураг төсөл”-д урьдчилсан байдлаар заавал тусгана.
  - “Үндсэн зураг төсөл”-тэй уялдуулж холболтын зураг төслийн санал боловсруулах, төсвийн тооцоолол хийсэн байна.
3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагуудаар хянуулан зөвшилцэж, магадлал, дүгнэлт хийлгэсэн зураг төсөл хүлээн авна.